

ДАНЗАНРАВЖААГИЙН ГОО ЗҮЙН ИЛЭРХИЙЛЭЛ

Б. Дэлгэрмаа

Доктор, дэд профессор

МУИС-ийн философи, шаашин судлалын тэнхимийн багш

Degi.muis@gmail.com

Д. Гоомарал

МУИС-ийн утга зохиол, урлаг судлалын тэнхимийн магистрант

Goomaral.d@gmail.com

Хураангуй: Данзанравжаагийн “Саран хөхөө”, “Хурмаст тэнгэр”, “Үлэмжийн чанар”, “Саруул тал” зэрэг гүн ухааны бүтээлүүд дэхь гоо зүйн илэрхийлэл болох сайхны тухай үзлийг тоймлон үзэв. Данзанравжаа сайхны тухай асуудлыг зөвхөн гадаад өнгө үзэмжийн асуудал биш, гадаад дотоод хоёр талын нэгдэл юм гэж үзсэн байна. Данзанравжаагийн шүлэг зохиол бүтээлүүдийн гүн утга санаа, ёс зүйн, гоо зүйн асуудал томоохон байрыг эзэлж байна.

Түлхүүр үгс: Сайхны тухай ойлголт, дуу, шүлэг, яруу найраг, урлаг, таван мэдрэхүй, гадаад гоо сайхан, сэтгэлийн гоо сайхан

I. УДИРТГАЛ ХЭСЭГ

XIX зууны үеийн Монголын гүн ухаантан, соён гэгээрүүлэгч, яруу найрагч, гоо зүйч Ноён хутагт Данзанравжаа 1803 оны гахай жилийн өвлийн дунд сарын шинийн 25-нд Шувуун шанд гэдэг газар буюу одоогийн Дорноговь аймгийн Хөвсгөл су Тэрээр манжийн Сайшаалт Ерөөлт хааны VIII он усан эм харгачингахай жил буюу 1803 онд эцэг Өлзийт буюу Дулдуйт хочит, эх Мажигхандхоёрын хөвүүн болон Түшээт хан аймгийн Мэргэн вангийн хошуу, одоогийн Дорноговь аймагт Шувуун хэмээх өчүүхэн шанд газар өвлийн дунд сарын 25-ны өдөр мэндэлжээ.

Таван настайдаа нутгийн нэг ноёны найран дээр “Хурмаст тэнгэр” хэмээх гүн ухааны шүлэг хэлж хавь ойрын хүмүүсийг алмайруулжээ. Шүлгийн үгийг дурдвал,

*“Үүл нь гараад бороо орохын цагт үүдэн гэмээ нь хойморьт нь ялгаан юун
Үйл нь ирээд үхэхийн цагт хөгшин гэмээ нь залуу ялгаа юун”* хэмээдэг билээ.

6 настайд нь ламын сахил хүртээсэн.

Бага наснаасаа өнчрөл ядуугийн зовлон үзсэн боловч өөрийн авъяас билгээрээ олонд хүндлэгдэж 9 настайдаа Говийн догшин ноён Хутагтын V дүрд өргөмжлөгджээ. 11 наснаасаа 15 хүртэл эдүгээ Өвөрмонголын нутаг дахь Бадгарчойлин хийдэд Буддын шашны гүн ухааны болон нууц тарнийн эрдэмд суралцсан. 16 настайдаа төрөлх нутагтаа эргэн ирж Өвөрбаясгалант Хамрын хийдээ байгуулж эхэлжээ. 18 настайд нь эцэг Дулдуйт нь таалал болов. Түүнээс хойшхи амьдралын он жилүүдэд нь сүм хийд байгуулах, говь нутгийг соён

гэгээрүүлэх үйлс бүтээл нь дэлгэрсэн байдаг.1856 онд Манжийн хаанд хорлогдон нирваан дүрийг үзүүлсэн ажээ. Гэгээнтний шарилыг таалал барьсан газарт нь буюу Өвөрмонголын нутаг дахь Бойны сүмийн газар занданшуулж, өөрийн төрөлх Хамрын хийдэд нь залсан байна.Нэг талаас бурхны хойд дүр гэгдэх, нөгөө талаас төрөлхийн авьяас, билэг заяасан энэ хүн 53 наслахдаа Монголын говь төдийгүй, Дорно дахинд алдаршсан соён гэгээрүүлэгч хүн байжээ.Говийн ноён хутагтад нийт 9 дүр тодорсон байна.

Гүн ухаантан, яруу найрагч, монголын театр урлагийг үндэслэгч Данзанравжаад Ванчин-Эрдэнийн гэгээнтнээс “Ноён хутагт Аграмба цоржийнхувилгаан” мөн хэмээн нэр өгч, улмаар даншиг хийж нууцаар халхын ноёнхутагтын Ү дүрээр тодорсон тэрээр монголын нийгэм соёлын нэрт зүтгэлтэйбайсан юм. Түүний намтарт “... Дундад оронд дуудуулсанд Жанжаа гэгээний хамтаар бараалхаж Түвандамцигсүмгодын авшиг хайрлахуйд “Аяа, Ноён хутагт Рэ-Хэ Бодлын газар тарнийн ном сайн уншсаны хүчээр тод хувилжээ” хэмээнайлдаж ялгуусан чин зоригт цол, таван олбог, мөнгөн завъяа, нанзад хадаг,хэрэглүүлэх ямба шагнасан ба дараа нь Түшээт ханаас хоёр олбог нэмж олгосон байна” хэмээн өгүүлснээ хутагтын нэр хүнд, монголын буддизмд эзэлж байсан байр суурийг харуулжээ.

Данзанравжаа (1803-1856 он) яруу найрагч, ая зохиогч, жүжгийн зохиолч, хөгжмийн зохиолч, найруулагч, зураач хүн байжээ. Тэрээр 300 гаруй шүлэг яруу найраг, жүжгийн зохиол 10 дэвтэр, 100 гаруй дуу зохиосон. Монгол хэлээр 200 гаруй бүтээл, төвд хэлээр 180 орчим зохиол бичжээ. Ноён хутагт Данзанравжаагийн бүтээлүүдээс бидэнд 200 орчим нь тодорхойболсон байна.

1830 онд Монголын анхны театр болох “Намтар дуулах дацан”-г байгуулж “Саран хөхөө” жүжгийг тоглуулан түүнийгээ нүүдэлчдийн өвөрмөц театр болгож, жүжгийн тоглолтоор дамжуулан монголчуудаа соён гэгээрүүлдэг байжээ. “Саран хөхөө” жүжиг нь бүтнээр тогловол сар тоглодог, мөн товчилсон хэлбэрээр 7 хоног тоглодог байв.

Зохиолоо өөрөө бичиж найруулан, дүрд тоглох хүмүүсийг сонгож, бэлтгэл сургуулилт хийлгэн, тайзны зургаа өөрөө зурж, жүжгийн ая дуу зэргийг зохион хөгжмийн бүтээл болгож байжээ. Данзанравжаа театрын найруулагч хүн байсан.

Монгол дахь дуулалт жүжгийн эх болсон догшин Ноён хутагт Данзан Равжаа (1803-1856) -ийн “Саран Хөхөө” дуулалт жүжгийн зохиол нь монголдоо анхдагч шинэ зүйл болж гарч ирсэн. Данзанравжаа XIX зууны монголын уран зохиолын гайхамшигт дурсгал болох “Саран хөхөөний намтар” дуулалт жүжгээ 1737 онд Төвөдийн хувилгаан Лувсандамбийжалцаны “Хөх хоолойт саран хөхөөний тууж”-аас сэдэвлэн бүтээжээ. Уг хоёр зохиолын

талаар доктор профессор С.Хөвсгөл “Д.Равжаагийн “Саран хөхөөний намтар жүжгийн “горим”-ын эх бичгийн судалгаа” хэмээх бүтээлдээ: ”тууж болон жүжгийн зохиол нь ялгаатай тус тусдаа биеэ даасан зохиол мөн” хэмээн онцлон тэмдэглэсэн. “Саран Хөхөө” жүжгийг дуулалт жүжиг байсан гэдгийн учир нь жүжигт ярьж хөдлөхөөс дуулах нь их байсан учраас дуулалт жүжиг хэмээх онцлог бий болгосон. лог бий болгосон.

Жүжигт тоглодог, дуулдаг хөгжимддөг, жүжигчдийн дийлэнх хувийг эмэгтэй хүмүүс эзэлдэг байсан нь Дорнын театрын хөгжилд төдийгүй Өрнийн театрт нэн ховор үзэгдэл байжээ. Учир нь XVII зууны үед ч Өрнөдийн театрын тайзнаа эмэгтэй хүний дүрд эрэгтэй хүн тоглодог байсныг харьцуулан үзэхэд Данзанравжаа дэвшилтэт үзэлтэй хүн байсан байна.

Данзанравжаа архитекторч хүн байсан бөгөөд газар шинжих уламжлалтаргыг сайтар эзэмшсэн бөгөөд 1820 онд 17 Насандаа Өвөр Хамар гэдэг газар Хамрийн хийд, 1840 онд Өмнөговь аймгийн Ханбогдод “Галбын гурван хийд” гэжалдаршсан Дэмчигийн хийд, Цагаан толгойн хийд, Эрээтийн хийд гэх мэт нийт 8 том хийдийг бариулж, зураг төсөл бүгдийг өөрөө гаргажээ. Дэмчигийн хийд нь Данзанражаагийн гол өргөө маягтай бөгөөд түүний эдлэл хэрэглэл, ном уншлага, сүм дацан, сургууль зэргийг дэргэдээ агуулсан томоо суурин газар байв.

Данзанравжаа гүн ухаанч хүн байсан бөгөөд нэг боть гүн ухааны зохиол туурвижээ. Тэрээр буддын гүн ухааны сэтгэл төдийтний чиглэлийн төлөөлөгч байсан бөгөөд түүний гүн ухааны үзэл санааг тусгайлан судалж эрдэмтэн Г.Лхагвасүрэн эрдмийн зэрэг хамгаалсан бүтээл бичсэн байна.

Данзанравжаа монголын буддын шашны нэрт зүтгэлтэн байв. Түүний амьдрал бүхэлдээ шашинтай холбоотой ч зарим нэгнээссийрүүлбэл, Данзанравжаагийн байгуулсан Дэмчигийн хийд буй газрыг дэлхийн эрчим хүчний цэг буюу Шамбалын орон гэж үзэж хүндлэх болсон байна. Түүнийг “Замбу тивд орших ариун таван орний нэг” хэмээг тал ч байна. Үүнд, “Замбутивийн ариун таван орон нь “Дорж дан буюу Бурхан багшийн гэгээрлийг олсончирт суудал”, “Утай таван уул буюу Манзушри бурахны орон”, “Үржин хандынорон буюу Агинаст дагинасын орон”, “Бодала буюу Дарь эх бурхдын орон”, “Шамбала буюу Цогт цагын хүрдний номлол ихэд дэлгэрсэн орон” зэргийгоруулдаг бөгөөд түүний байгуулсан орон хийдийн нутгийг эдгээр лүгээ адилтган үздэг.

Данзанравжаа тухайн үеийнхээ бүтээн байгуулагч нь байв. Тэрээр зөвхөн 13-41 насны хооронд таван хийдийг байгуулсан тухай намтарт нь бий юм.

Хамарын хийд нь Данзанравжаагийн гол өргөө маягтай байсан бөгөөд түүний эдлэл хэрэглэл, ном уншлага, сүм дацан, сургууль зэргийг дэргэдээ агуулсан Монголын том суурин газар байв. [1]. Данзанравжаа гүн ухаанч хүн

байсан бөгөөд нэг боть гүн ухааны зохиол туурвижээ. Хамарын хийд болон Дэмчогийн хийд буй газрыг дэлхийн эрчим хүчний цэг буюу Шамбалын орон гэж үздэг бөгөөд энэ нь “оюуны орон” гэсэн үг юм.

II. ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Гоо зүйн шинжлэх ухааны салбарт онолын хувьд нэгдүгээрт, сайхны тухай асуудал, хоёрдугаарт урлагийн мөн чанарын тухай асуудал юм. Ноён хутагт Данзанравжаа түүний гоо сайхны сэтгэлгээг дараах онол арга зүйгээр тоймлон үзвэл:

Сайхан нь юмс үзэгдлийн дотоод, гадаад талуудын өөр хоорондын нарийн зохицолдлогоот зүй зохистой холбоотой юм.

Сайхан нь юмс үзэгдэл бүхэнд харилцан адилгүй байх буюу харьцангуй шинжтэй байна.

Сайхан нь хүний амьдрал, үйл ажиллагаанд үр ашигтай нөлөөлөх шинж чанарыг агуулж байна.

Сайхан нь объектив үндэстэй байна.

Сайхныг хүн тусган авч танин мэддэг төдийгүй бас бүтээлч үйл ажиллагаагаараа буй болгож болно.

Мөн инээдэмт явдлыг шинжлэх ухааны категори болохынх нь хувьд авч үзэж байгаагүй боловч инээдэмт зүйлийн гол агуулга буюу шүүмжлэлт шинж болон түүний илрэх үндсэн хэлбэрүүд болох шог, хошин, егөөдлийн уран бүтээлдээ хэрэглэсэн. Данзанравжаа гоо сайхны мэдлэгийн ерөнхий цар хүрээний нэг үзүүлэлт болгон үзсэн байна. [2]. Данзанравжаагийн зохиосон янаг амрагийн сэдэвтэй иргэний уянгын бүтээлүүд нь түүний уран бүтээлийн ихэнх хувийг эзэлдэг юм. Түүний бичсэн “Хөвчийн өндөр”, “Үзэсгэлэнт хангай”, “Галын магтаал”, “Үлэмжийн чанар” зэрэг бүтээлүүд нь эх үрийн элбэрэл хайр, байгаль орчны сайхныг магтан дуулсан төдийгүй байгалийн үзэгдэл нь хүний хүсэл зоригоос үл шалтгаалан оришж байдаг гэсэн гүн ухааны утга гүнзгий санааг агуулсан байдаг юм. Данзанравжаагийн бүтээлүүдэд танин мэдэхүйн асуудал ч дэвшүүлэгдэн гарч байсныг анхаарах нь зүйтэй. Тэр байгалийн юмс үзэгдлийг танин мэддэг гэсэн санааг уран сайхны аргаар гаргаж тавьсан байна. Үүнийг байгалийн гоо сайхнаар илэрхийлсэн “Үлэмжийн чанар” гэдэг ихэд алдаршсан бүтээлээс тодорхой харж болно.

Данзанравжаа хүрээлэн байгаа ертөнцийг хүн танин мэдэж чадна. Танин мэдэхүйн үйл ажиллагаа нь юмс үзэгдлийн тодорхой шинж чанарыг хүн мэдрэхүйн эрхтнээрээ дамжуулан сэтгэхүйдээ тусгаж хүлээн авах явдал мөн гэдэг санааг гаргасан байна. Данзанравжаагийн бүтээлүүдэд байгаль ертөнц,

хүний үйл ажиллагааны зүй тогтол, хувиралт өөрчлөлтийн шалтгаан мөнх бусын ёс зэрэг гүн ухааны асуудлууд багагүй тусгагдсан байдаг. Ялангуяа юмсын дотоод шалтгаанаараа хувиран өөрчлөгдөж байдаг гэсэн диалектик үзэл илэрч байна. Данзанравжаа уран бүтээл бодит амьдрал хоёрын диалектик нэгдлийг бэхжүүлж объектив үнэнийг уран сайхны аргаар нээж үзүүлэхийг гол зорилгоо болгон тавьж байжээ.

Ингэснээрээ тэр урлагийг бодит байдлыг танин мэдүүлэх нэг хэрэгсэл болгон ашигласан юм. Өөрөөр хэлбэр, ертөнцийн хувиралт өөрчлөлт, амьдралын жам хуулийг урлагаар илэрхийлж үзүүлэхийг чармайж байсан ажээ. Амьдралын үнэнийг уран сайхны аргаар тод яруу дүрслэн үзүүлсэн танин мэдэхүйн өндөр ач холбогдол бүхий урлагийг хөгжүүлсэн явдал бол шинэчлэлийн бас нэг гол шинж мөн.

Иргэншлийн шинжийг агуулсан урлагийн бүтээл нь ноёрхогч ангийн явцуу хүрээнээс халин гарч харин хөдөлмөрчин олон түмний эрх ашиг, хүсэл эрмэлзлийг илэрхийлж чадах болсоноороо ихээхэн онцлогтой юм. Ард түмний цэцэн ухаан, урлах арга барилын ширгэшгүй ундаргад тулгуурлан ардын уралгийн уламжлалтай гүн гүнзгий холбоо тогтоосон нь их амжилтанд хүрчээ.

Данзанравжаагийн зохиол бүтээл хэллэг, зохиомжийн хувьд ардын аман зохиолтой ихээхэн төсөөтэй юм.

Данзанравжаагийн иргэний уянгын бүтээлүүд нь ч, уг ая хоёр нь дуулалт жүжиг нь ч, олон уран бүтээлчдийг удирдан найруулах чадвар нь өгүүлэн буй үеийн урлагийн амьдрал дахь урьд өмнө төдийлөн байгаагүй сонирхолтой бөгөөд шинэ үзэгдэл байлаа.

Энэ шинэ үзэгдэл нь урлаг, утга зохиолыг урагш ахиулж хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр болж чадсанаараа чухал ач холбогдолтой шинэчлэл байв.

Ш. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

2006 онд ЮНЕСКО Данзанравжаагийн таалал төгссөний 150 жилийн ойг тэмдэглэн “Хөгжмөөс эхлээд архитектур, философи, театр зэрэгт авъяас чадвартай Буддын сэтгэгч Дулдуйтын Данзанравжаа нь Монгол Улсын хил хязгаараас давж сэтгэлгээ, соёлд чухал нөлөө үзүүлсэн. Түүний асар олон бүтээлийг одоо Монголын уламжлалт соёлыг сэргээхээр дахин нээж байна” гэжээ. 1950-иад оны сүүлчээр Монголын нэрт зохиолч Ц.Дамдинсүрэн нь Данзанравжаа судлалын анхдагч болов. Данзанравжаагийн эртний монгол судлаачдын хийсэн судалгаа түүний “феодалын”, “хоцрогдсон” үзлийг шүүмжилдэг. Сүүлийн жилүүдэд Данзанравжаагийн яруу найраг, уран зохиолын талаар нэлээд их судалгаа шинжилгээ хийгдсэн.

Л.Хүрэлбаатар “Д.Равжаа Судлалын Тойм”-доо “Түүний философи, ялангуяа хайр болон бясалгалын талаарх түгээмэл тайллууд нь хэт нэг талыг барьсан байдалтай байдаг” гэж бичжээ.

Данзанравжаа яруу найрагч дуун ухааныг туйлд нь хүртэл судалсан бөгөөд шүлэгт мөрийн тоог цэгтэй, үеийг тохируулах, толгой, сүүлийг уран яруу холбож, адилтгал, зүйрлэл чимэглэлүүдийг өргөн хэрэглэж чаддаг гарамгай яруу найрагч хүн байв. Түүнчлэн зохиол туурвилыг нь эрдэмтэн судлаачид, урлаг соёлыхон, энгийн иргэдийн анхаарлыг татаж ирсэн байна. Түүний зохиосон “Хурмаст тэнгэр”, “Өвгөн шувуу”, “Үлэмжийн чанар”, “Түвшин сайхан”, “Төрүүлж өсөгсөн гөрөөс ээж”, “Маанийн магтаал”, “Асрийн өндөр” зэрэг дууг Говь, Хангай нутаг болоод Улаанбаатар хотын ард иргэд, урлаг соёлын зүтгэлтнүүд мөн Өвөр Монголд “Авралт гурван чухаг” хэмээх Маанийн магтаалийг нь өнөөдрийн өдөр хүртэл дуулж байгаа болно. Тухайн оршин буй нийгмийнхээ, ялангуяа эрх баригч ихэс дээдэс, ламхуваргуудын ёс суртхууны уналт доройтлыг товойтол нь илчилж шүүмжилжбайсан юм. Эл доройтлыг жигдрүүлэн засах арга замын талаар тодорхой үзэлсанааг дэвшүүлэн гаргаж тавьж байсан нь түүний дэвшилт үзэл санааны илрэл юм. Тухайн үеийн Монголын нийгмийн бодит байдал, сав шим ертөнцийн гоо сайхан, ард нийтийн хүсэл эрмэлзлэлийг бодит байдлаар дэлгэн илэрхийлснээрээ Монгол орны нийт ардын сэтгэл зүрхэнд хүрч хадгалагдан, дуулагдсаар ирсэн юм. Данзанравжаа 7 настайдаа нутгийн нэг ноёны найран дээр “Хурмаст тэнгэр” хэмээх гүн ухааны шүлэг хэлж хавь ойрын хүмүүсийг гайхашруулжээ. Уг шүлэгт:

“Үүл нь гараад бороо орохын цагт

Үүдэн гэмээ нь хоймор юуны ялгаа байх вэ,

Үйл нь байгаад үхэхийн цагт

Хөгшин гэмээ нь залуу юуны ялгаа байх вэ” гэжээ.

Говийн ноён хутагт Данзанравжаа гоо сайхны тухай ойлголтыг “Үлэмжийн чанар”, “Саруул тал” зэрэг дуунууддаа идэрхийлэн гаргасан байна.

Академич Ц.Дамдинсүрэн “. . . “Үлэмжийн чанар” гэдэг дууг хүний нүд, чих, хамар, хэл, бие, таван эрхтний хүчээр мэдэрч чадах дүрс, дуун, үнэр, амт, хүрэлцэхүй тавыг багтаасан таван бадгаар зохиожээ хэмээсэн байна. Судлаач Д.Цагаан “Таван тахил буюу Үлэмжийн чанар” хэмээх дууныхний бадагт хүний нүдэнд тусах эмэгтэйн гаднах өнгө үзэмж үзэсгэлэнт дүрсийг, II бадагт гоо бүсгүйн сэтгэлд хоногшим яруу дууг, хөхөө шувууны эгшигтэй адилтган, III бадагт гоо бүсгүйн сэтгэл татах сайхан үнэрийг анхилам зандантай адилтгаж, IV бадагт амтыг, зөгийн дурыг татагч бал бурмын амттай адилтган дүрсэлжээ” хэмээсэн байна. Доктор Л.Хүрэлбаатар “...Үлэмжийн

чанар хэмээх энэ дуу нь нэг талаар амрагийн буюу гоо сайхан эмэгтэйн магтаал хэмээжээ. [1].

Ноён хутагт олон зүйлийн дуу, гүр дуу зохиосний дотор монголчуудындунд хамгийн их түгэн дэлгэрсэн нь “Үлэмжийн чанар” бүтээл нь болно. Энэ дууг “Өнгө сайг таван тахил” гэж нэрлэж байжээ. Тэрээр “Үлэмжийн чанар” дуундаа эмэгтэй хүний гоо сайхныг ийнхүү магтан дуулжээ:

“- Үлэмжийн чанар төгөлдөр

Өнгө тунамал толь шиг

Үзэсгэлэнтэй сайхан царайг чинь

Үзээд үзээд ханашигүй ээ.”

(Энд харах мэдрэхүй илэрч байна.)

“-Хөшүүн сэтгэлийг уяруулдаг

Хөхөө шувууны эгшиг шиг

Хөөрхөн эелдэг үг чинь

Хүүрнэн суухад урамтай

Хөөрхөн аальт мину зээ.”

(Энд сонсох мэдрэхүй илэрч байна.)

“-Учирмагц сэнгэнэсэн

Уран гол шиг бие чинь

Улаан занданы үнэр шиг

Улмаар сэтгэлийг хөдөлгөнөм зээ.”

(Энд үнэрлэх мэдрэхүй илэрч байна.)

“-Бадмын дундаас дэвэрсэн

Балын амт адил

Баясгалантай хөөрхөн царайг чинь

Бахархаад бахархаад ханашигүй ээ.”

(Энд амтлах мэдрэхүй илэрч байна.)

“-Хүмүний энэ насанд

Хүссэн хэргээ бүтээгээд

Хүсэлт тэнгэрийн адил

Хөлгүй жаргалын далайд

Хөвж хамт жаргая” хэмээн өгүүлжээ.

(Энд хүрэлцэх мэдрэхүй илэрч байна.)

Ийнхүү Данзанравжаа харах, сонсох, амтлах, үнэрлэх, хүрэлцэх таван мэдрэхүйд тулгуурлан эмэгтэй хүний гоо сайхныг магтан дуулжээ. Ноён хутагт Равжаагийн ихэнх дуунд тэр минь, энэ минь, түүндээ хүрье,үүндээ золгоё гэсэн үг бий. Үүгээр бид тэдгээр дууг янаг амраг хайр сэтгэлийн уянга гэж гагц талаар нь эдүгээчлэн ойлгож болохгүй. Түүний нь цаана

хэлсэнбуддын санааг эрхбиш харгалзан үзэх хэрэгтэй. Энд жишээ болгож “Тэргэл сарныгэрлийн тунгалаг нь” гэдэг нэгэн дууны тухай өгүүлье.

Тэргэл сарны гэрлийн тунгалаг нь

Тэнгэр газрын энгийн уужим нь

Тэрний минь зангийн сэргэлэн нь

Тэгш гагц сэтгэлийн амар нь

Наана тунгалаг уужим сэтгэлийн янагийн сэтгэлийн сайхныг дуулсан мэт боловч цаана нь тэргэл саран мэт гийлсэн билгүүний их гэгээ тэнгэр газар мэт арга билгийн хослол, барилдлага түүнд шүтсэн амгалан хоосны хурц үзэлт тэр хоёрын оносон сэтгэлийн их амирлыг өгүүлсэн юм.

Настай буурал өвгөн эцэг

Намайгаа гэж суугаа болов уу

Арга үгүй үүлэнд найдаж явж

Арайхан хожуу төөрөлдөв үү

Эндэх санаа нь энэ мэт ажил үйлийн эрхээр эцэгтэйгээ уулзалгүй хол төөрөлдсөн нэгний сэтгэлийн гомдлыг өгүүлсэн төдий биш эртнээс үйлдэждадсан муу үйлийн эрхээр эцэг болсон хоосон чанрын үзэлтэй их хожуу чирсаныг өгүүлсэн тухай байна. [2]. Мөн Данзанравжаа “Саруул тал” дуундаа:

“Саруул тал байвч

Шавартай газрыг нь мэдээрэй,

Сайхан амраг байвч

Санаа сэтгэлийг нь таниарай.

Уужим тал байвч

Устай намагтайг нь мэдээрэй,

Учирсан амраг байвч

Ухаан сэтгэлийг нь таниарай.

Нугалзуур модны мөчрөөс

Морио битгий аргамжаарай,

Мохоо сэтгэлтэй хүнд

Сэтгэлээ битгий өгөөрэй.” гэж бичжээ.

Данзанравжаа сайхны тухай асуудлыг зөвхөн гадаад өнгө үзэмжийн асуудал биш, гадаад дотоод хоёр талын нэгдэл юм гэж үзсэн байна. [3]. Энэ нь манай ардын уламжлалт мэдлэгтэй холбоотой. Монголчууд “Хүний эрээн дотроо, могойн эрээн гаднаа”, “Хүний сайныг ханилан байж мэд, хүлгийн сайныг унан байж мэд” гэж ярьдаг бөгөөд эдгээр ардын зүйр цэцэн үгэнд сайхан болон сайн гэдэг бол шууд танигддаггүй, удаан хугацааны дараа танигддаг гэсэн санаа байна.

Монголчууд сайн, сайхан гэсэн ойлголтуудыг нягт холбон авч үздэг билээ. Данзанравжаа өөрийн уран бүтээлдээ хүмүүний гоо сайхан ба, хүний үйл амьдрал, нийгмийн амьдралын сайхан, муухайн олон талт байдлыг илтгэн харуулсан байдаг. Гоо зүйн шинжлэх ухааны гол ойлголт нь сайхны тухай ойлголт байдаг. Орчин үеийн гоо зүйн шинжлэх ухаанд сайхныг “Агуулга ба хэлбэр, мөн чанар ба үзэгдлийн зүй зохистой нэгдэл” гэж үздэг. Данзанравжаагийн уран бүтээл дэх сайхны тухай ойлголт нь үүнтэй таарч тохирч байна. [4].

XIX зууны сүүлч үе, XX зууны эхэн үед Монголын урлагт шүүмжлэлт хандлага, иргэншлийн хандлага бий болсон юм. Манай сэтгэгчид өөрсдийн зохиол бүтээлүүддээ гоо зүйн нэг гол ойлголт болох инээдэмтэйн тухай үзэл санааг боловсруулж байсан. Данзанравжаа “Ичиг, ичиг” шүлэгтээ:

“Номоо мэддэггүй лам нар ичиг ичиг,

Төрөө мэддэггүй ноёд ичиг ичиг,

Айлаа мэддэггүй хүүхнүүд ичиг ичиг” гэжээ.

Мөн Данзанравжаа цааш нь ийнхүү өгүүлжээ. Үүнд:

“Аяа бас буйн хураасангүй насажсан хөгшид ичиг ичиг,

Аяа, бас сэтгэлээ зассангүй гангалагч залуучууд ичиг ичиг,

Аяа, бас аавыгаа өргөхгүй эрийг өргөгч охид ичиг ичиг,

Аяа, бас өөрийн гэмийг үзэхгүй бусдын гэмийг гаргагч хэрсүүчүүд ичиг ичиг,

Аяа, бас өөрөө айл хэсэж ирээд эхнэрээ шаргагч эрчүүд ичиг ичиг,

Аяа, бас эрчүүдийн үгэнд орохгүй бусадтай ханилагч эхнэрүүд ичиг ичиг,

Аяа, бас энэ гэмүүд надад буй бол олны дундаас би ганцаар ичиг ичиг,

Аяа, бас хэрэв бусад их багад буй бол хэн ч бол тэр ичиг ичиг” 27 гэжээ.

Энэ бүхнээс харахад, Данзанравжаа олз хүндлэл, хувийн ашиг хонжоо, нэр алдрын төлөө бол юунаас ч буцахгүй атлаа, эрдэм номын төлөө, бусдад хэрэг тустай нийтийн сайн үйлийн төлөө явдаггүй, үнэнч шударга биш, ажил, амьдралын утга учрыг өнөө маргаашийн идэх хоол, өмсөх хувцас, эд баялаг төдийгөөр хязгаарлагч, нийгмийн ёс горимыг үл тоомсорлогч нарыг шүүмжилжээ.

Тухайн үеийн нийгмийн доройтол, үйл ажиллагааны гаж буруу байдлыг үл тэсвэрлэж, хурцаар шүүмжлэх байдал урлаг, уран зохиолд тод илэрч байв. Данзанравжаа зэрэг сэтгэгчид лам, ноёдоос айж эмээлгүй тэр үеийн нийгмийн байдлыг ил тод шүүмжилж байв. Энэ үеийн монголын урлаг, уран зохиолд шүүжлэлт реализмын шинж голлож байсан. [5].

Ёс суртахууны алдаа доголдол сайн мууг өгүүлж, хувь хүний болоод нийгмийн гишүүн бүрийн ёс зүй, хүнийг шинжин таних харилцах арга эв дүй,

хандлагыг өгүүлээд, цааш нь ёс суртахууны дутагдал, доголдлыг засахад сургаал хэрэгтэй гээд ямар хүнд сургаал хэрэгтэй, ямар хүнд сургаал хэрэггүйг тоочин өгүүлсэн нь сурган хүмүүжүүлэх ач холбогдолтой юм. Энэ үзэл нь түүний “ Цагийн жамыг тодруулагч цаасан шувуу” зохиолоор илэрнэ. Энэ сургаал нь хязгаар газрын нэгэн хүн (төр гэрэлтийн) тавдугаар оны барс сарын арван наймны шөнө зүүдэлж байгаа хэлбэрээр, цаасан шувуу нисгэгч, түүнийг сонирхогч хоёрын асуулт хариултын яриагаар дамжуулан тухайн үеийн нийгмийн анги давхарга, тэдгээрийн үйл ажиллагаа, зан суртахууны доголдол, доройтлыг нээн дэлгэсэн шүүмжлэл, сургаал хосолсон зохиолын нэг юм. Уг сургаалд цаасан шувуу нисгэгчийн үгээр:

...Энэ цагийн хүний зовлон гэвэл,

Цайруу явбал хүний гарт орно

Хардаж явбал муу үйл арвидна

Шударга явбал олонтой үл таарна

Башираар явбал номтой үл таарна

Чанга хурц явбал өстөн олон болно

Дуугүй номхон суувал толгой дээр гарна

Дундуур энгийн явбал тэнэг гэж сонжлогчид олон...

гэж хүмүүсийн ая нь олдохгүй олон янзын ааш араншинг халаглан шүүмжилжээ. Энэ шүүмжлэл нь хэзээ боловч үнэ цэнэтэй хэвээрээ байна. Мөн уг зохиолдоо:

Ёстныг хүндэл

Настныг баярлуул

Бачтанаас зайл

Сайнаас бүү сал...

(Биеийн явдалд)

Хэрцгийлж хэрүүл бүү үүсгэ

Хэлбийж олон янз бүү урва

Ховсорч хэрэггүй үг бүү зөө

Хуурч элдэв башир бүү хэл...

(Хэлний өгүүлэх)

Шинжлэлгүй бүү сэтгэ

Сэрэмжгүй бүү зальхайр

Гэнэт нөхрийг бүү итгэ

Гэндэж хүнээс бүү урьт...

(Сэтгэлийн чиг) гэж амьдралд ухаалаг хандаж, өөрөө өөрийгөө зөв залж, удирдаж явахыг сургамжилсан нь хүмүүжлийн ач холбогдолтой зөв зүйтэй санаа юм.

Мөн асуулт асуугч хүний “Энэ цагийн жам ямар вэ?” хэмээсэн асуултанд хариулагч хүн “Аяа, аяа, хохой, энэ цагийн хүний явдлыг санах тутам ертөнц лүгээ нөхцөхийн чагтага тасран, зүрх догдлох мэт энэ бөлгөө” гэж халаглаад хариултаа эхэлдэг. Түүний хариултын мөр бүрт “Аяа бас” гэсэн үг орсон байгаагаас ажиглахад энэ ертөнцийн болохгүй бүхий л зүйлсийг тоймлон шүлэглэсэн нь илэрхий. Жич:

...Аяа бас,

Хариугүй өглөг үл өгнө

Харгүй сайхан сэтгэлээр үл санана

Атгаггүй амархан сууж үл чадна

Аргачлалгүй явдал үл явна

Юмыг тоололгүй алба үл гаргана

Зүгээр суугаад, алдрын төлөө эд мал зарагчид олон

Өвдөж сандравч хайргүй өргөгчид цөөн

Муу үйл үйлдээд үл гэмшигчид олон

Сайн явдлыг яваад баярлагч хүн цөөн...

Зөвхөн муу муухай, болохгүй бүтэхгүй асуудлыг дурьдаад зогсохгүй тэдгээрийг засан залруулах аргыг тодорхой оруулсан мөртүүд ч олон бий. Асуулт асуугч хүн шувуу нисгэгчээс үйл хөдлөл, сэтгэл санаа, хүсэл мөрөөдлийн талаар онцгойлон лавлаж асуухын зэрэгцээ зориг хүч өгөх үг хайрлаач хэмээн хүсдэг байгаа. Хариуд нь цаасан шувуу нисгэгч:

...Урьдын хийсэн хилэнцээс

Хор уусан хүн мэт хашир

Магад гарах буянт сэтгэлийг

Амь мэт энхрийл

Хилэнцэт нөхрөөс

Аварга могой үзсэн мэт зайл

Буяны саданг өөрийн толгой мэт өргө

Сэтгэлийн эрдмийг яст мэлхийн гишүүн мэт нуу

Усгал зөөлөн занг мөрний урсгал мэт ундраа

Чин зориг, хичээнгүйг буугийн сум мэт чиглэ

Гурван эрдэнийн үйлст морь, нохой мэт зүтгэ

Олон хамаг амьтанд сал онгоц мэт

Боол сэтгэлийг барь

Тангараг цааз хоёрыг шил толь мэт хайрла

Өөрийн гэмийг салхи мэт алдаршуул... хэмээжээ.

Уг сургаалийн мөн чанар гаргалгааг тайлбал муу муухай явдлын гол буруутан нь хүмүүс өөрсдөө байна. Иймээс хүний зан суртахуун, ааш араншингийн хир буртгийг ариутган цэвэрлэх, засан өөрчлөх, цаг үеийг

сайжруулах хэрэгтэй гэсэн санааг дэвшүүлжээ. Уг сургаалаас ажиглахад Данзанравжаа нь Монгол үндэснийхээ аман зохиол, зан үйл зэргийг сайн мэддэг зохиолч байжээ.

IV. ДҮГНЭЛТ

Гоо зүйд сайхны тухай ойлголт гол байр суурьтай байдаг. Данзанравжаа сайхны тухай асуудлыг зөвхөн гадаад өнгө үзэмжийн асуудал биш, гадаад дотоод хоёр талын нэгдэл юм гэж үзсэн байна. Тэрээр сайхны тухай ойлголтонд гадаад гоо сайхнаас гадна сэтгэлийн гоо сайхныг чухалчлан үзэж байв. “Үлэмжийн чанар”, “Саруул тал” дуундаа эмэгтэй хүний гоо сайхныг магтан дуулжээ. Ийнхүү Говийн Ноён хутагт Данзанравжаа гоо зүйн тухай ойлголтыг өөрийн шүлэг, дуугаараа илэрхийлэн гаргаж байжээ. Уран бүтээлээс нь үзэхэд Данзанравжаа гоо зүйч хүн байжээ гэж дүгнэж үзэж болох юм.

Данзанравжаа гоо зүйн сайхны тухай ойлголт, инээдэмтэйн ойлголтыг өөрийн зохиол бүтээлээрээ дамжуулан боловсруулж байсан байна. Данзанравжаагийн зохиол бүтээл, дуу, шүлэг яруу найргийн гүн гүнзгий утга санаа нь өнөөдөр ч үнэ цэнээ алдаагүй байна. Залуучууд бид түүх, соёлоо судалж монголын сэтгэгчдийнхээ ёс зүй, гоо зүйн сургаалыг нь амьдралдаа хэрэгжүүлэх нь чухал юм гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

[1]. Монголын философийн түүх. (XVIII-XIX зуун). (2001). IY дэвтэр.

[2]. Хүрэлбаатар, Л. (2006) Аварга могойн зулайн чандмань.

[3]. Лхагвасүрэн, Г (2003). Ноён хутагт Данзанравжаа.

[4]. Төмөрбаатар, Ж. (2012). Монголын гоо сайхны сэтгэлгээний түүхэн тойм.

[5]. Дэлгэрмаа, Б. (2011). Гоо зүй.

[6]. Дэлгэрмаа, Б. (2012). Урлагийн философи